



Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газар

# САНХҮҮГИЙН АУДИТЫН НЭГТГЭСЭН ТАЙЛАН

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГААС 2022 ОНЫ ШИЛЭН ДАНСНЫ ТУХАЙ ХУУЛИЙН  
ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН АУДИТЫН НЭГТГЭЛ ТАЙЛАН

Баруун-Урт сум 2023 он



Дарга, тэргүүлэх аудитор Г.Даваа

Утас: 70518396 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитын менежер М.Нарантуяа

Утас: 70512123 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: Barchidgunseno@audit.gov.mn

## АГУУЛГА

|                                                                                                      |   |
|------------------------------------------------------------------------------------------------------|---|
| АГУУЛГА .....                                                                                        | 2 |
| Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл .....                           | 3 |
| 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 108 зөрчил илэрсэн .....                   | 4 |
| 2. Шилэн дансны тухай хуулийн зарчмыг зарим төсөвт байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлсэн байна. .... | 6 |
| 3. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дийлэнх байгууллагууд хугацаа хоцроож мэдээлжээ. ....      | 6 |
| ДҮГНЭЛТ .....                                                                                        | 7 |
| САНАЛ .....                                                                                          | 8 |

### Товчилсон үгийн жагсаалт

|          |                                                      |
|----------|------------------------------------------------------|
| УИХ      | Улсын Их Хурал                                       |
| ОНӨААТҮГ | Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар |
| ИТХ      | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал                         |
| ШДНЦХ    | Шилэн дансны нэгдсэн цахим хуудас                    |

## Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

|                                           |                                                                                                                                                                                                                                                                                                                                                             |
|-------------------------------------------|-------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|
| <b>Аудит хийх үндэслэл, бүрэн эрх</b>     | Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”- заасны дагуу аудитыг гүйцэтгэсэн.                                                                            |
| <b>Аудитын зорилт</b>                     | Бүх шатны төсвийн захирагч, төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, тэдгээрийн үйл ажиллагаанд санхүүгийн сахилга, бат, төсвийн ил тод, үр ашигтай байдалд аудит хийж дүгнэлт гарган, зөвлөмж боловсруулж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, иргэд, олон нийтэд, мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ. |
| <b>Аудитын хамарсан хүрээ</b>             | Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-3.1.5 дахь хэсэгт заасан төсвийн байгууллага, сангууд, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд, төрийн өмчит үйлдвэрийн газруудыг хамруулан гүйцэтгэлээ.                                                                                                                                           |
| <b>Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт</b> | “Шилэн дансны” тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих бодлого, чиглэлийн хүрээнд холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнг боловсруулна.                  |

## 1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар 108 зөрчил илэрсэн

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах 13 төсвийн төвлөрүүлэн захирагч, 147 төсвийн байгууллага, 18 орон нутгийн өмчит аж ахуйн нэгж, 31 тусгай сан, 2 төрийн өмчит компани нийт 211 байгууллагыг хамруулан, аудитыг гүйцэтгэсэн.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Сүхбаатар аймгийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар харьяа байгууллагуудад нийт 108 зөрчил илэрсний 34 зөрчилд албан шаардлага, 74 зөрчлийг зөвлөмж болгосон.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроосон, авлага, өр төлбөрийн тайлбар, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нийтлэг зөрчил илэрлээ. Үүнийг төсөв захирагчаар ангилан хүснэгтээр харуулбал:

### Аймгийн Засаг дарга болон түүний харьяаны байгууллагууд

| Төсөв захирагч      | Хуулийн заалт                                                | Алдаа зөрчлийн төрөл                                                                                                                    | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|---------------------|--------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                     |                                                              |                                                                                                                                         |             | Албан шаардлага | Зөвлөмж |
| Аймгийн засаг дарга | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалт | Шилэн дансны цахим системд зээлийн санхүүжилтийн захирамж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй. | 14          | 9               | 5       |
|                     | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт | Байгууллагын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй   | 15          | 8               | 7       |
|                     | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл                     | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн                          | 21          | 5               | 16      |

### БШУС-ын харьяа байгууллагууд илэрсэн зөрчлийн мэдээлэл:

| Төсөв захирагч        | Хуулийн заалт                                                | Алдаа зөрчлийн төрөл                                                                                     | Нийт зөрчил | / Тоон мэдээллээр /<br>Үүнээс |         |
|-----------------------|--------------------------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-------------------------------|---------|
|                       |                                                              |                                                                                                          |             | Албан шаардлага               | Зөвлөмж |
| Боловсрол сайдын багц | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалт | Шилэн дансны цахим системд зээлийн санхүүжилтийн захирамж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, | 2           | 1                             | 1       |

|  |                                                              |                                                                                                                                       |    |  |    |
|--|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|--|----|
|  |                                                              | зарлагын гүйлгээг мэдээлээгүй.                                                                                                        |    |  |    |
|  | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт | Байгууллагын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй | 3  |  | 3  |
|  | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл                     | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн                        | 27 |  | 27 |

### ЭМС-ийн харьяа байгууллагын зөрчлийн мэдээлэл:

| Төсөв захирагч | Хуулийн заалт                            | Алдаа зөрчлийн төрөл                                                                                           | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|----------------|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                |                                          |                                                                                                                |             | Албан шаардлага | Зөвлөмж |
|                | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн | 12          | 3               | 9       |

### ХЗДХС-ийн харьяа байгууллагын зөрчлийн мэдээлэл:

| Төсөв захирагч | Хуулийн заалт                            | Алдаа зөрчлийн төрөл                                                                                           | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|----------------|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                |                                          |                                                                                                                |             | Албан шаардлага | Зөвлөмж |
|                | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн | 4           | 0               | 4       |

### ХХААХҮС-ийн харьяа байгууллагын зөрчлийн мэдээлэл:

| Төсөв захирагч | Хуулийн заалт                                                | Алдаа зөрчлийн төрөл                                                                                                                  | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|----------------|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                |                                                              |                                                                                                                                       |             | Албан шаардлага | Зөвлөмж |
|                | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт | Байгууллагын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй | 1           | 1               |         |
|                | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл                     | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн                        | 1           | 1               |         |

### Соёлын сайдын харьяа байгууллагын зөрчлийн мэдээлэл:

| Төсөв захирагч     | Хуулийн заалт                                                | Алдаа зөрчлийн төрөл                                                                                                                    | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|--------------------|--------------------------------------------------------------|-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                    |                                                              |                                                                                                                                         |             | Албан шаардлага | Зөвлөмж |
| Соёлын сайдын багц | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь заалт | Шилэн дансны цахим системд зээлийн санхүүжилтийн захирамж, таван сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй. | 1           | 1               |         |
|                    | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт | Байгууллагын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээллийг нэгдсэн цахим системд               | 1           | 1               |         |

|  |                                          |                                                                                                                |   |   |   |
|--|------------------------------------------|----------------------------------------------------------------------------------------------------------------|---|---|---|
|  |                                          | мэдээлээгүй                                                                                                    |   |   |   |
|  | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл | Мэдээллийг <a href="http://www.shilendans.gov.mn">www.shilendans.gov.mn</a> хуудсанд хугацаа хоцроож мэдээлсэн | 3 | 1 | 2 |

## Прокурорын байгууллага

| Төсөв захирагч | Хуулийн заалт                                                | Алдаа зөрчлийн төрөл                                                                                                                  | Нийт зөрчил | Үүнээс          |         |
|----------------|--------------------------------------------------------------|---------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|-------------|-----------------|---------|
|                |                                                              |                                                                                                                                       |             | Албан шаардлага | Зөвлөмж |
|                | Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь заалт | Байгууллагын төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг мэдээллийг нэгдсэн цахим системд мэдээлээгүй | 1           | 1               |         |

## 2. Шилэн дансны тухай хуулийн зарчмыг зарим төсөвт байгууллагууд хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан “үнэн зөв, бодиттой, иж бүрэн, ойлгомжтой, ач холбогдолтой, тогтоосон хугацаанд тогтмол шуурхай мэдээлдэг байх”, зарчмыг зарим төсөвт байгууллагууд хангалтгүй мөрдөж байна. Тухайлбал: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогыг /санхүүжилтийг/ тус бүрээр мэдээлээгүй зөрчил нийтлэг байна. Үүнд: Сумдын ОНХС, Засаг даргын Тамгын газар гэх мэт.

## 3. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг дийлэнх байгууллагууд хугацаа хоцроож мэдээлжээ.

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” заасныг тогтмол мөрдөлгүй, Төсвийн захирагч нар хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгаан тайлбар, орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэлийн мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь байгууллагын нягтлан бодогч нар ЗГ-ын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар хавсралт маягтын дагуу мэдээлсэн боловч шалтгаан, тайлбарыг тодорхой оруулаагүй дутуу орхигдуулсан байна.

Мөн батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланг сар бүр мэдээлсэн эсэхийг авч үзэхэд төсвийн гүйцэтгэлийн мэдээг зөрүүтэй болон дутуу мэдээлэх, хоосон тэмдэглэгээ хийх, хугацаа хоцроох зэрэг нийтлэг зөрчил гаргаж тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2<sup>1</sup> дахь заалтыг бүрэн хангаагүй байна. Тухайлбал:

- *Асгат, Сүхбаатар, Баруун-Урт, Мөнххаан сумын Засаг даргын тамгын газрын төсвийн шууд захирагч мэдээг хугацаа хоцроож мэдээлсэн.*

<sup>1</sup> хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор;

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5-д заасан “Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого”.....-ыг хугацаа хоцроож мэдээлсэн зөрчил нийтлэг байна. Тухайлбал:

- *Дарьганга сумын Засаг даргын тамгын газар, Уулбаян, Наран, Эрдэнэцагаан сумын Эрүүл мэндийн төв, Дарьганга, Мөнххаан, Эрдэнэцагаан сумдын хоршоо хөгжүүлэх сан мэдээлэл хоцроосон.*

Тайлант онд аудитад хамрагдсан байгууллагын хэмжээнд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах захирамж, тушаал гарсныг зарим байгууллага мэдээлээгүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 6.4.8-д заасныг зөрчиж байна.

ШДНЦХ-ны төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тушаал шийдвэрийг мэдээлэх хэсэгт “Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр” зэрэг олон төрлийн мэдээллийг нэг дор байршуулахаар байгаа нь хүндрэл үүсгэж байна. Тухайлбал маш олон мэдээллийг агуулсан шийдвэрүүдийг хавсаргах нь хэрэглэгчид очих мэдээлэл ойлгомжгүй болох, нэг дор мэдээллүүд давхардах, мэдээлэл байршуулах албан тушаалтан бүрэн судлахгүйгээр орхигдуулах зэрэг нөхцөл байдал үүсэж байна. Тухайлбал:

- *Сумын ОНХС, Эрүүл мэндийн төвүүд шийдвэрийг дутуу буюу хоцроож мэдээлсэн байна.*

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, мэдээллийг иж бүрэн, үнэн зөв мэдээлэх талаар төсөв захирагч нар онцгой анхаарч, харьяа байгууллага, албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг үнэлэхэд Төсвийн тухай хуулийн 40.5<sup>2</sup>-т заасныг бүрэн хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг дүгнэхэд шалгуур үзүүлэлтийг тодорхой болгож, дотоод хяналт шалгалтыг чанаржуулахгүй бол хууль хэрэгжихгүй, зөрчигдсөөр байна.

## ДҮГНЭЛТ

Хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээллийг зарим төсөвт байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст бүрэн гүйцэт байршуулаагүй, мэдээллийн самбарт байршуулах мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд нь мэдээлэхгүй байх зөрчил давтагдсаар байна.

---

<sup>2</sup> Төсвийн ерөнхийлөн захирагч энэ хуулийн 40.1-д заасан үр дүнгийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг харгалзана.

Жил бүр санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчлийг холбогдох албан тушаалтанд танилцуулж зөрчлийг тухай бүр арилгуулж байгаа боловч хуулийн хэрэгжилт бүрэн хангагдахгүй байгаа бөгөөд хариуцлага тооцох асуудал дутагдалтай байна.

Шилэн дансны нэгдсэн сайтад оруулах мэдээллийг хуульд заасан хугацаанаас хоцроосон, авлага, өр төлбөрийн тайлбар, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр авлага үүсгэсэн аливаа шийдвэр, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг мэдээлээгүй нийтлэг зөрчил илэрлээ.

## **САНАЛ**

1. ШДНЦХ-ны төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тушаал шийдвэрийг мэдээлэх хэсэгт *“Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн шийдвэр”* зэрэг олон төрлийн мэдээллийг нэг дор байршуулахаар байгаа нь хүндрэл үүсгэж байгаа учир хөгжүүлэлт хийх асуудлыг уламжилж өгнө үү
2. Зөрчил давтагдаж байгаа асуудалд хариуцлагын шат дараалсан арга хэмжээ авах эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

**СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**